

## ЦАГДААГИЙН БАЙГУУЛЛАГЫН ХҮНИЙ НӨӨЦИЙН СОНГОН ШАЛГАРУУЛАЛТАД САХИЛГА, ЁС ЗҮЙГ ОНЦГОЙ АНХААРАХ НЬ

### Б.Нямдаваа

Дотоод хэргийн их сургуулийн Удирдлагын академийн 8011 дүгээр дамжааны суралцагч, цагдаагийн хошууч

**Төвч агуулга:** Цагдаагийн байгууллагын хүний нөөцийн сонгон шалгаруулалт, алба хаагчдаас үйлдсэн зөрчил, сахилга, ёс зүйн байдалд үнэлэлт дүгнэлт өгөх, бодит судалгаанд үндэслэн алба хаагчийн сахилга, ёс зүйг сайжруулах чиглэлээр шинэ, санал, санаачилга гарган цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанд нэвтрүүлэхэд оршино.

**Abstract:** It is to make new proposals and initiatives in the field of police recruitment, violations committed by the police officers, discipline and ethics based on real research, and introduce new ideas and initiatives in the field of improving officer discipline and ethics

**Түлхүүр үсс:** Цагдаагийн байгууллага, сонгон шалгаруулалт, алба хаагч, сахилга, ёс зүй.

Key words: Police, recruitment, officer, discipline, ethics

**Оршил.** Монгол Улсын Их Хурлын 2020 оны 05 дугаар сарын 13-ны өдрийн 52 дугаар тогтоолоор “Алсын хараа 2050” урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгийг баталсан. Энэхүү баримт бичгийн 7 дугаар бүлэгт хүний эрх, эрх чөлөөг хамгаалах, амар тайван аюулгүй нийгмийг бүрдүүлэх, хууль сахиулах салбарын хөгжлийн чиг хандлагын талаар тодорхой тусгаж өгчээ. Тухайлбал “Алсын хараа 2050” урт хугацааны бодлогын баримт бичгийн зорилт 7.4.2 дахь хэсэгт “Хууль сахиулах салбарын эрх зүйн орчныг сайжруулан, ажиллах

нөхцөлийг дээшлүүлж, мэргэшсэн чадварлаг хүний нөөцийг бэлтгэн өрсөлдөх чадварыг хөгжүүлэх” гэж заасан<sup>72</sup>.

Дээрх зорилттой уялдуулан мэргэшсэн, чадварлаг, сахилга, ёс зүйтэй хүний нөөцийг бүрдүүлэх хэрэгцээ, шаардлага тулгараад байна.

Цагдаагийн байгууллага нь Монгол Улсын Үндсэн хууль, Цагдаагийн албаны тухай, Монгол Улсын Засгийн газрын тухай, Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай, Цэргийн алба

<sup>72</sup> Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоол. “Алсын хараа 2050” урт хугацааны бодлогын баримт бичиг.

хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулиуд, бусад хууль, цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны дүрэм, журам, зааврыг үйл ажиллагаандaa мөрдлөг болгон ажилладаг.

Түүнчлэн үйл ажиллагаандaa хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэх, ил тод, нээлттэй байх, нууцыг чанд хадгалах, олон нийтийн итгэл хүлээж, дэмжлэг авах, үйл ажиллагаа нь тасралтгүй байх, улс төрөөс ангид байх, нэгдмэл төвлөрсөн удирдлагатай байх зарчмыг баримтална.

Цагдаагийн албан хаагчид нь авлигаас ангид түүнтэй эвлэршгүйгээр тэмцэх чиг үүрэгтэй, шатлан захирах хатуу сахилга баттай, удирдлагаас өгсөн заавар тушаал гарсан даруйдаа хэрэгжиж байдаг онцлогтой.

Цагдаагийн байгууллагын үйл ажиллагаа нь хуулийн хүрээнд явагдах хэдий ч байгууллага хуулиар олгогдсон эрх, үүргээ хэрэгжүүлэх нь эрх зүйн орчноос гадна алба хаагчдын сахилга, ёс зүй, хувь хүний хүмүүжил, боловсролтой шууд хамаарлтай гэж үзлээ.

Цагдаагийн албан хаагчийн үйлдэл болон эс үйлдэхүйн хэлбэрээр гарч буй сахилга, ёс зүйн ба эрх зүйн зөрчлүүд нь хүний нөөцийн судалгаа, хувь хүний хүмүүжил, боловсролоос шууд хамаардаг.

Манай улсын 1990 оны ардчилсан хувьсгалын шинэчлэлтэй холбогдуулан, Цагдаа, дотоодын цэргийн бүрэлдэхүүн салбарын болон байгууллагын удаа дараагийн бүтцийн өөрчлөлт, орон тооны цомхотгол зэргээс үүдэлтэй албан тушаалын зэрэглэл, тогтолцоо, шатлал байнгын шинжтэй өөрчлөгдөж, үүний улмаас төрийн албаны залгамж чанар, тогтвортой байдал алдагдаж алба хаагчдын сэтгэлгээ, ажилд хандах хандлага хүний нөөцийн бодлого, асар их өөрчлөлт бий болж, алба хаагчдын сахилга, ёс зүйн зөрчил дутагдал арилахгүй байгааг жил бурийн сахилгын мэдээ, тоо баримтаас харж болох ба албаны нууцад хамаарах мэдээ, мэдээлэл байгаа учраас тоо баримтыг дэлгэрэнгүй судалгааны ажилд дэлгэрэнгүй дурдах боломжгүй юм.

Алба хаагчдаас гаргах сахилга, ёс зүйн зөрчил дутагдлыг бууруулах, цаашлаад байгууллагын хүний нөөцийн аюулгүй байдлыг хангах, мэргэшсэн боловсон хүчиний хэрэгцээ шаардлага байгаа учраас энэхүү сэдвийг сонгон судалгааны ажлаа хийсэн болно.

### Үндсэн хэсэг

Ёс зүй хэмээх ойлголт нь эртний Грекийн Ethos буюу хамтран амьдрах, оршин амьдрах газар гэдэг утгатайгаар илэрхийлэгддэг. Хожим нь хөгжлийн явцад “ёс заншил, зан төлөв, зан араншин, сэтгэлгээний хэв маяг” гэсэн агуулгатай болж,

тэдгээрийн шинж чанарыг илэрхийлэх болсон.

Аристотель хүний зан төлөвийн өвөрмөц шинжийг илэрхийлэхийн тулд ёс зүй гэдэг нь хүний сайн сайхан үйлийг хэлнэ гэж тодорхойлсон.

Монгол хэлнээ “ёс” нь хүний дагаж баримтлах хэв, хууль журам, зарчим, харин “зүй” нь аливаа юмны тогтоол жам ёс, сургаал онол гэсэн утгыг илэрхийлдэг.

Иймээс ёс зүйг утгын хувьд “аливаа хүний баримтлах журам, зарчмын сургаал онол” гэж ойлгож болно.<sup>73</sup>

Ёс зүй гэдэг нь нийгмийн хэм хэмжээнд зохицон биеэ авч явахыг хэлнэ. Харин нийгмийн хэм хэмжээнээс гажууд, зохисгүй зан үйл гаргахыг ёс зүйгүй үйлдэл гэнэ<sup>74</sup>.

Цагдаагийн алба хаагчийн сахилга, ёс зүйг Цагдаагийн ерөнхий газрын даргын 2022 оны А/201 дугаартай тушаалаар батлагдсан “Цагдаагийн алба хаагчийн ёс зүйн дүрэм”, “Цагдаагийн алба хаагчийн сахилгын дүрэм”-үүдэд зааснаар...,

“Цагдаагийн алба хаагчийн ёс зүйн хэм хэмжээ” гэж энэ дүрмээр тогтоосон ёс зүйн нийтлэг хэм хэмжээ, түүнд нийцүүлэн гаргасан тушаал, шийдвэр, түүнчлэн нийгэм, хамт олон, гэр бүлийн харилцааны хүрээнд дагаж мөрдвөл зохих зан үйлийн нийлбэр цогцыг;

-“Цагдаагийн алба хаагчийн ёс зүйн зөрчил” гэж холбогдох хууль тогтоомж болон энэ дүрмээр тогтоосон ёс зүйн хэм хэмжээг зөрчсөн үйлдэл, эс үйлдэхүйг;

**-“Цагдаагийн алба хаагчийн сахилга”** гэж Монгол Улсын хууль тогтоомж, тэдгээрт нийцүүлэн гаргасан эрх зүйн акт болон байгууллагын дотоод журам, цагдаагийн алба хаагчийн тангаргаар хүлээсэн үүргээ чанд сахин биелүүлэхийг;

**-“Сахилгын зөрчил”** гэж холбогдох хууль тогтоомж болон энэ дүрмээр тогтоосон сахилгын хэм хэмжээг зөрчсөн үйлдэл, эс үйлдэхүйг;<sup>75</sup> гэж тодорхойлсон байна.

Цагдаагийн байгууллагын алба хаагчийг сонгон шалгаруулахдаа дараах хууль, дүрэм, журмын хүрээнд сонгон шалгаруулалт явуулж, хүний нөөцийг бүрдүүлж байна.Үүнд:

Төрийн албаны тухай хуульд ....Төрийн жинхэнэ албан тушаалд Монгол Улсын 18 нас хүрсэн, дээд боловсролтой, монгол хэлний ярианы болон бичгийн чадвартай, сэтгэцийн өвчин, эмгэггүй, хуулийн дагуу цэргийн жинхэнэ алба хаах үүргэг хүлээсэн иргэн үүргээ биелүүлсэн, Эрүүгийн хуульд заасан авлига,

<sup>73</sup> Төрийн албан хаагчийн ёс зүй гарын авлага УБ хот -2019 он

<sup>74</sup> [www.slideshare.net](http://www.slideshare.net)

<sup>75</sup> ЦЕГ-ын даргын 2022 оны А/201 дүрэм батлах тухай тушаал

албан тушаалын гэмт хэрэг үйлдэж шүүхээр ял шийтгүүлж байгаагүй байх иргэнийг сонгон шалгаруулж томилооор заасан.

Цагдаагийн албаны тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.2 дахь хэсэгт Иргэнийг цагдаагийн албанд анх томилохдоо гэмт хэрэг үйлдэж ял шийтгүүлж байгаагүй, нас, эрүүл мэнд, бие бялдар, боловсрол, мэргэжил, мэргэшил, ёс зүйн болон бусад тусгайлсан шалгуур үзүүлэлтийг хангасан 18 насанд хүрсэн Монгол Улсын иргэнийг хүсэлтийг нь үндэслэн шалгуур хангасан байдлаар нь эрэмбэлэн, цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам, кодод зааснаар шалгаруулж цагдаагийн байгууллагад томилдог.<sup>76</sup>

Иргэнийг судлан цагдаагийн байгууллагад томилохдоо хүний нөөцийн судалгааг бүрэн гүйцэт сайн хийгээгүй, тухайн иргэний гэр бүлийн орчин, хувь хүний хүмүүжил, боловсрол, сэтгэл зүйн онцлог, нийгэмшил, урьд өмнө гэмт хэрэг, зөрчилд холбогдсон эсэхийг сайтар судлаагүйн улмаас тухайн иргэн цагдаагийн албаны бүрэлдэхүүнд орж, томилогдсоны дараа сахилга, ёс зүйн зөрчил гаргах, цаашлаад гэмт хэрэг, зөрчилд холбогдох, албаны нэр хүндийг унагах, бусад алба хаагч нарт сөрөг, буруу үлгэр дуурайлал үзүүлэх байдал таслан

зогсоогдохгүй, бүрэн арилахгүй байна.

Иймээс одоо ажиллаж буй цагдаагийн алба хаагчдаас түүврэлэн сонгож, тухайн алба хаагчдын хувийн байдлыг тогтоох, урьд өмнө гэмт хэрэг, зөрчилд өртсөн, холбогдсон эсэх, ямар зөрчил дутагдалд нийтлэг холбогдож байгааг тодруулах, цаашид анхаарах асуудлыг тогтоох зорилгоор Цагдаагийн байгууллагын нэгдсэн сангаас түүврийн аргаар тодорхой тооны алба хаагчийн мэдээллийг шүүж, дүн шинжилгээ хийж үзэхэд “цагдаагийн алба хаагч болохоос өмнө бусдын амгалан тайван байдлыг алдуулж, хэрүүл маргаан үүсгэж танхайрсан, архи, согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн үедээ тээврийн хэрэгсэл жолоодсон, жолоодох эрхээ хасуулсан, замын хөдөлгөөний дүрэм зөрчсөн, эрүүгийн хэрэгт холбогдон шалгагдаж байсан, тодорхой бус шалтгааны улмаас эрэн сурвалжлагдаж байсан” зэрэг судалгааны дүн гарч байна.

Дээрх түүврийн аргаар сонгож авсан алба хаагчдыг ажиллах хугацаанд сахилга, ёс зүйн зөрчил дутагдал гаргасан эсэхийг судалж үзэхэд “Сахилга, ёс зүйн болон зөрчил” үйлдэж хариуцлага хүлээсэн судалгааны үр дүнгээс харахад дахин зөрчил дутагдал

<sup>76</sup> Цагдаагийн албан тухай хууль-УБ хот-2017 он /шинэчилсэн найруулга/

үйлдэх, бусдад хамт олонд сөргөөр нөлөөлөх магадлалтай байна.<sup>77</sup>

### Дүгнэлт

Судалгааны дүнгээс үзэхэд хувь хүний суурь хүмүүжил бүрэн төлөвшөөгүй, аливаа хорт муу зуршилтай, зөрчил үйлдэж байсан иргэнийг бүрэн дүүрэн судлахгүйгээр цагдаагийн байгууллагад томилон ажиллуулсан тохиолдолд албанаас олгогдсон эрхийг өөрийн дадал зуршлын дагуу буруугаар ашиглаж, аливаа гэмт хэрэг, зөрчилд холбогдох, албаны нэр төрийг унагах, албан үүргээ биелүүлж чадахгүйгээс гадна хамт олон, нийгэмд сөргөөр нөлөөлөх эрсдэл үүсч болзошгүй.

Хууль, дүрэм, журмын хүрээнд болзол, шалгуурыг хангаж байгаа иргэнийг цагдаагийн байгууллагад элсүүлэн ажлуулж байгаа нь Монгол Улсын үндсэн хуулинд заасан “Ажил мэргэжлээ чөлөөтэй сонгох, хөдөлмөрийн аятай нөхцөлөөр хангуулах, цалин хөлс авах”, хүний эрхийг хангаж байгаа ч цагдаагийн байгууллагын чиг үүрэг, хууль сахиулах үйл ажиллагааг хэрэгжүүлэх, иргэдтэй хууль, дүрэм, журмын хүрээнд харьцах чадваргүй, байгууллага, хамт олны нэр хүндийг унагах, сахилга, ёс зүйн зөрчил дутагдал гаргах үйлдэл тасрахгүй байх магадлалтай байна.

### Санал

Иймд цагдаагийн байгууллагад шинээр орох, бие бүрэлдэхүүний эгнээнд элсүүлэх иргэнийг сонгон шалгаруулахдаа бүх талаас нь нарийвчлан судалдаг болох, эрх бүхий албан тушаалтан /хүний нөөцийн ажил хариуцсан/-уудын бүх төрлийн санд нэвтрэх эрхийг нэмэх, шаардлагатай тохиолдолд төрөл, мэргэжлийн албаар судлуулж, сөрөг мэдээллүүдийг нэн тэргүүнд илрүүлдэг болох, цаашлаад ухамсар соёлын түвшин, суурь хүмүүжил, аливаа муу зуршилгүй иргэнийг сонгон шалгаруулдаг байх чиглэлээр удирдлага, зохион байгуулалтын арга хэмжээг оновчтой авч хэрэгжүүлснээр хүний нөөцийн аюулгүй байдал хангагдаж, зөрчил, дутагдлаас ангид байж, чадварлаг хамт олныг бүрдүүлнэ гэж үзлээ.

Түүнчлэн цагдаагийн байгууллагын алба хаагчдыг үе шаттай сурган дадлагажуулах, мэргэшсэн боловсон хүчин бэлтгэх, хэрэгцээ, шаардлага байгаа учраас давтан, мэргэшүүлэх сургалтуудад шат дараатайгаар хамруулах ажлыг тасралтгүй зохион байгуулах.

Эх сурвалжийн жагсаалт.

9. Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоол.  
“Алсын хараа 2050” урт

<sup>77</sup> Цагдаагийн байгууллагын гэмт хэрэг, зөрчлийн сан

- 
- хугацааны бодлогын баримт бичиг.
10. Төрийн албан хаагчийн ёс зүй гарын авлага УБ хот - 2019 он
11. Цагдаагийн ерөнхий газрын даргын 2022 оны А/201 дүгээр тушаал.
12. Цагдаагийн албаны тухай хууль-УБ хот-2017 он /шинэчилсэн найруулга/
13. [www.slideshare.net](http://www.slideshare.net)
14. [www.google.mn](http://www.google.mn)
15. [www.legalinfo.mn](http://www.legalinfo.mn)
16. Цагдаагийн байгууллагын нэгдсэн сан